| 236 | | 4.1.5.3. Захиргааны шийдвэр гаргах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | - | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналд иргэдээс авах саналын хувь | | Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналт тавьж, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч хэрэгжүүлнэ. | 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх ажлын хүрээнд 1-р улиралдаа багтаан өрх бүрд саналын хуудас тарааж, иргэдээс санал авах маягт цахим байдлаар 56200 иргэнээс санал авч багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэн 335 ажил, төсөл арга хэмжээг эрэмбэлж аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 9159,3 сая төгрөгийн 60 ажил хэрэгжүүлж ажиллалаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөн батлуулахдаа иргэдийн 80-аас доошгүй хувийн оролцоог хангах журмыг баримтлан, санал аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн журамд тусган хэрэгжүүлэхгүй байхад анхааран 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17 сум, 6 тосгоны хэмжээнд хэрэгжих 10,9 тэрбум төгрөгийн 335 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сангийн хөрөнгөөр 10,4 тэрбум төгрөгийн 60 төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг зохион байгуулсан | |
| 237 | 4.1.6. Олон Улсын болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлж, уламжлалт харилцааг бэхжүүлэн шинэ түншлэлийг нэмэгдүүлж, гадаад хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ. | 4.1.6.1. Аймаг, орон нутгийн онцлог, нөхцөл боломжийг харгалзан гадаад харилцааны шинэ түншлэлийг нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжиж ажиллах | 8 улс, 2 муж, 7 хот, 6 Элчин сайдын яам, 1 консулын газар, 1 төлөөлөгчийн газар, 7 олон улсын байгууллагатай хамтын ажиллагаатай ажиллаж байна | Аймаг орон нутгийн онцлог, нөхцөл боломжийг харгалзан гадаад харилцааны шинэ түншлэл тогтоосон тоо | | Хамтын ажиллагааны шинэ түншлэлийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Сэлэнгэ аймаг болон БНСУ-ын Дангжин хот хоорондын түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж газар тариалан, эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэгийн салбар чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. Мөн БНСУ-ын Үньпён дүүрэгтэй мэргэжлийн боловсон хүчнийг сургаж дадлагажуулахад хамтран ажиллах талаар санал тусгаж харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. “Гадаад харилцааг эдийн засагжуулах нь” хөтөлбөрийн хүрээнд ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын тэргүүн Алексей Самбуевич Цыденовтой 2 удаагийн хэлэлцээр хийж, БНБУ-д сурах хүсэлтэй оюутнуудад хөнгөлөлт үзүүлэх, орос хэлний багш нарыг бэлтгэх, дадлагажуулах, хилийн ойр бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, хавдрын цөмийн эмчилгээний төвтэй хамтран ажиллахаар болсон. БНСУ-ын Жежү мужтай боловсрол шинжлэх ухааны чиглэлээр төрийн албан хаагчдыг харилцан туршлага судлуулах, орчин | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үеийн ухаалаг техник технологийг нэвтрүүлэх тэдгээртэй холбоотой инновацыг нутагшуулахаар ажиллаж байна. Сөүл хотын Үньпён дүүрэгтэй эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах, Япон Улсын Шизоука мужийн Озава тент ХХК-тай хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт тус улсын технологийг нэвтрүүлэх, нарийн ногооны өвлийн хүлэмж байгуулах, орчин үеийн инновац нэвтрүүлэхэд хамтран ажиллахаар харилцан тохиролцоод байна. БНХАУ-ын Хар мөрөн мужийн Харбин хоттой аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тус хотын Мөсөн урлалыг Сэлэнгэ аймагт орон нутгийн онцлог төрхийг шингээсэн арга хэмжээг зохион байгуулах, туршлага судлахаар саналыг хүргүүлээд байна. ОХУ-ын Эрхүү хотын их дээд сургуулиудтай боловсролын салбарт хамтран ажиллах, аймгийн сурагчдыг тус хотод хөнгөлөлттэй нөхцөл, боломжоор сургахад хамтран ажиллахаар урьдчилан тохиролцоод байгаа бөгөөд холбогдох баримт бичгийг бүрдүүлэн дээд шатны байгууллагад хүргүүлээд байна. Канад Улсын Элчин Сайдын яамтай хүнс, хөдөө аж ахуй хөнгөн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлдвэрлэлийн салбарт хамтрахаар харилцан тохиролцоод байна. | |
| 238 | | 4.1.6.2. ОХУ, БНХАУ, Япон улсын Шизуока мужтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, аймаг, муж, хотуудын соёл, урлаг, боловсрол, спорт, эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх | ОХУ-ын Буриад Улс, Хиагт, Зед, Сэлэнгэ, Кабанский муж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Хар мөрөн муж, Япон улсын Шизуока мужтай хөдөө аж ахуйн салбат хамтран ажиллаж байна. | ОХУ, БНХАУ, Япон улсын Шизуока мужтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, аймаг, муж, хотуудын соёл, урлаг, боловсрол, спорт, эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагаа байгуулсан ажил, арга хэмжээний тоо | | Хамтын ажиллагааны санамж бичгийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг холбогдох журмын дагуу гаргаж, өргөжүүлнэ. | Япон Улсын Шизуока мужтай 2 удаа хүнс, хөдөө аж ахуй, газар тариалан, нарийн ногооны чиглэлээр цахим уулзалтыг зохион байгуулсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хоттой цар тахлын нөхцөл байдлын талаар харилцан туршлага солилцох цахим уулзалтыг зохион байгуулсан. ОХУ-ын БНБУ-ын Улан-үдэ хот, Сэлэнгэ аймагт Эдийн засгийн форумыг хамтран тус тус зохион байгууллаа. БНХАУ-ын ӨМӨЗО-ын хамтын ажиллагааны хүрээнд тус улсын Хөх хоттой ах дүүгийн найрамдалт хамтын ажиллагааг өргөжүүлэх мөн цахим хөгжил дэд бүтэц инновацын ажлын хүрээнд тус улсаас манай аймагт хурлын ухаалаг дэлгэцийн дэмжлэг үзүүлээд байна. Япон Улсын Шизоука мужтай газар тариалангийн чиглэлээр хамтран ажиллаж ирсэн бөгөөд дээрх чиглэлийн ажил арга хэмжээг өргөтгөх, салбар чиглэлийг нэмэгдүүлэх талаар харилцан санал солилцож санамж бичгийн төслийг тус муж руу хүргүүлэхээр бэлтгээд байна. Тус мужтай газар тариалангийн хүний нөөцийн чиглэлээр хэд хэдэн хамтарсан сургалтыг зохион байгуулаад байгаа | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бөгөөд Сэлэнгэ аймгийн газар тариалангийн чиглэлийн төрийн албан хаагчдыг богино хугацааны сургалтад хамруулаад байна. Энэ 2024 онд аймгийн төрийн албан хаагчдыг мэргэжил ур чадвар дээшлүүлэх богино хугацааны хөтөлбөрт хамруулахаар төлөвлөөд байгаа бөгөөд тус мужийн газар тариалан нарийн ногооны чиглэлийг судалгааны мэргэжилтнүүдийг урьж ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна.ОХУ-ын БНБУ-ын Хиагтын аймагтай олон жилийн уламжлалт найрсаг хамтын ажиллагааны хүрээнд өмнө нь байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн батлах, тухайлсан салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр урьдчилан тохиролцоод байна. | |
| 239 | | 4.1.6.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Олон улсын төсөл хөтөлбөрүүдийн газруудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх | Жайка, Койка, ГОУХАН, ТИКА, АДРА, Дэлхийн зөн Монгол зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | Шинэ түншлэлийн тоо | - | Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн газруудад хамтын ажиллагаааны санал тавьж, хамтран ажиллана. | АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Best” хөтөлбөртэй хамтран төсөл хэрхэн бичих вэ, санхүүгийн мэдлэг олгох, гарааны бизнесийг дэмжих зэрэг сэдвээр 17 суманд 110 удаагийн сургалт зохион байгуулж 3012 иргэниг хамруулан, 3,5 тэрбум төгрөгийн зээл авахад дэмжиж ажилласан. 2023 оны санхүүгийн жилд 5 бүлэгт 50 сая төгрөгийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | буцалтгүй тэтгэлэлг олгож, ажлын байр бий болгосон. “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран 3 хөтөлбөрийн хүрээнд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилттэй төсөл арга хэмжээг 7 сум, 2 тосгонд хэрэгжүүлж ажилласан. “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд төрийн албан хаагч, багийн Иргэдийн Нийтийн хурлын зөвлөлийн гишүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж, сумдын ОНХС-ын гүйцэтгэлд үндэслэн 2016-2023 онд 3,0 сая төгрөгийн урамшуулал олгож ажилласан. 2023 оноос Органик хөдөө аж ахуйн түншлэл 2 төсөл нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Герман АДРА ОУБ байгууллагын 1,6 сая еврогийн санхүүжилтээр 2023 оны 10 дугаар сарын 01-нээс 2026 оны 12 дугаар сарын 31-ны хооронд 41 хоршоонд хэрэгжиж эхлээд байна. | |
| 240 | 4.1.7. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх мэдээллийн дэд бүтцийг | 4.1.7.1. Орон нутгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санг нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх | - | | Нэвтрүүлсэн байгууллагын тоо | | Сумдын ЗДТГ-т цахим мэдээллийн санг нэвтрүүлсэн байна | “Сэлэнгэ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан”-г нэвтрүүлэхээр “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллагатай хамтран санал солилцож, “Орон нутгийн мэдээллийн дэд бүтэц” төслийг боловсруулсан. Тус төсөлд нэвтрүүлэлтийн зардлыг 14.5 сая төгрөг, хамтын ажиллагааны буюу | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглээнд нэвтрүүлнэ. | | | | | | үйл ажиллагааны зардлыг 24.9 сая төгрөгөөр тус тус тооцож санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Олон Улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудад хандаж байна. Тус ажлыг хэрэгжүүлэхээр аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд мөн тусгасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан цахим мэдээллийн санг нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажилласан боловч төсөв шийдэгдээгүй байна. | |
| 241 | | 4.1.7.2. Орон нутгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх | Аймгийн Засаг даргын 2017 оны А/458 тоот захирамжаар батлагдсан журмыг мөрдөж ажилладаг | Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг боловсруулж, мөрдсөн эсэх | | Журмын дагуу захиргааны байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д бүх шатны захиргааны байгууллага өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгж, эсхүл ажилтантай байхаар тусгасан боловч Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахтай | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | холбогдуулан холбогдох сум, агентлагуудаас орон нутгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулах талаар санал аваагүй болно. | |
| 242 | 4.1.8. Орон нутгийн төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичигт төлөвлөлт, явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг тооцох тогтолцоог бэхжүүлнэ. | 4.1.8.1. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж, удирдлагуудыг мэдээллээр хангаж, иргэд олон нийтэд мэдээлэх | - | Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн бодлогын баримт бичгийн тоо | | 6-аас доошгүй | “Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын дагуу аймаг маань дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдээ хуульд заасан хугацаанд нь боловсруулан батлуулсан. Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулсан бөгөөд өмнө нь үндсэн чиглэлийг ингэж таван жилээр буюу дунд хугацаагаар баталж байсан тохиолдол байдаггүй. “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” шинэчлэгдсэнээрээ аймаг маань дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй болсон бөгөөд Аймгийн МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 75, АН-ын мөрийн хөтөлбөрөөс 17, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 13 төлөөлөгчөөс 76 санал ирүүлснийг судлан үзэж, боловсруулж байсан. Үүний дагуу аймгийн Иргэдийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар хамтран аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 5 бүлгийн 15 дэд бүлэг, 165 зорилтын хүрээнд “Хүнээ дээдэлж-Хамтдаа хөгжье” эрхэм зорилготойгоор боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн залгамж чанарыг хадгалж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2016-2020 онд нийт 39 баримт боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг эхлүүлээд байсныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж жил бүр хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэж үнэлгээ дүгнэлт өгч, тодорхой үр дүнд хүрсэн. Цаашид урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэхээр бид төлөвлөсөн хугацаандаа хэрэгжилтийг хангуулан ажиллахаар шат шатандаа ажиллаж байна. | |
| 243 | | 4.1.8.2. Төрийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн | | 5-аас доошгүй | “Сэлэнгэ-Энерго”, “Цөм сүрэг”, “Барилга захиалагч”, “Сэлэнгэ Орон сууц” зэрэг ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | газруудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааг сайжруулах | | байгууллагын тоо | | | аймгийн Засаг даргын батласан удирдамжийн дагуу шинжилгээ, дотоод аудит хийж, зөвлөмж, албан шаардлагуудыг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Дотоод аудитаар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь их хэмжээний өр үүссэн, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл учирч байгаа нь нийгмийн суурь үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжид хүргэхэд томоохон хүндрэл үүсгэж байна. Цаашид төрийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааг сайжруулах талаар анхаарч ажиллаж байна. | |
| 244 | | 4.1.8.3. Төрийн байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцсан ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх | - | Мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн төрийн албан хаагчдын тоо | | 40 албан хаагч | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг сум, тосгодод зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, 17 сумдад ажилласан ажлын хэсгүүд сумдын Засаг даргын Тамгын газрын тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүд болон төсвийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад анхан шатны Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн сургалтыг зохион байгуулан ажилласан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 245 | 4.1.9. Баг, тосгодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна. | 4.1.9.1. Багийн Засаг дарга нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх | - | Мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн багийн Засаг даргын тоо | | 57 баг | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Алсын хараа 2050", “Хөдөөгийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймаг “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээний хүрээнд 57 багийн чадавхийг нэмэгдүүлэх, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэх зорилгоор багийн хөгжлийг дэмжих зорилгоор төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг анхан шатны нэгж буюу багийн хөгжлийг дэмжих зорилгоор үйлчилгээг шат шатнадаа түргэн шуурхай үзүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн Засаг дарга нарыг чадавхжуулах, иргэн төвтэй хөгжлийн үзэл баримтлалыг түгээж засаг захиргааны анхан шатны нэгжийн удирдлагын хандлагыг өөрчлөх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай мэдлэгийг дээшлүүлэх, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор багийн Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг 17 сумдын 57 багийн Засаг дарга нарыг 2024 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд сургалтад хамруулахаар бэлтгэл ажлыг эхлүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 246 | | 4.1.9.2. Зарим сумдын багуудыг байртай болгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх | - | Барьсан багийн байрны тоо | | 2 | Төрийн анхан шатны нэгж багийн үйл ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн 45.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ерөө сумын 2 дугаар багийн байр, улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын Цагаан-Эрэг 2 дугаар багийн байруудыг ашиглалтад оруулж өрхийн эмнэлэг, багийн ажилтнууд үйл ажиллагаа явуулж, иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Баянгол сумын Баян багийн байрны дулааны асуудлыг шийдвэрлэж, урсгал засварыг хийсэн. Сайхан сумын Засаг даргын Тамгын газар нь багийн Засаг даргын албан өрөөний зориулалтаар сумын Засаг даргын Тамгын газрын залгаа өргөтгөлийг худалдан авч, эхний ээлжинд 15.0 сая төгрөгөөр аж ахуйн аргаар засвар үйлчилгээ хийж, 2023 оны аймгийн төсөвт тус багийн байрыг засварлаж дуусгахаар төлөвлөсөн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан засварын ажил хийгдээгүй байна. | 90% |
| 247 | 4.1.10. Аймгийн хэмжээний үйл ажиллагааны цар хүрээтэй, орчин цагийн | 4.1.10.1. ”Хэвлэл-мэдээлэл, олон нийттэй харилцах алба”-ны бүтцийг тогтоож, багаж тоног | - | Албаны бүтэц бүрэлдэхүүнийг баталж, үйл ажиллагааг | | Олон нийттэй харилцах албаны бүтцийн дагуу | Аймгийн ЗДТГ-ын хэвлэлийн багийн бүтцийг ХШҮХ-д байхаар тогтоож, бүрэлдэхүүнд шинээр зураглаач, графикч, сэтгүүлч мэргэжлийн боловсон хүчин авч, хэвлэлийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэвшилтэт технологийн чанарын шаардлага хангасан “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба” байгуулна. | төхөөрөмжийг шийдвэрлэх | | жигдрүүлсэн байна. | | ажиллаж эхэлсэн байна. | багийн үйл ажиллагааг жигдрүүлсэн. Хэвлэлийн багийн анхан шатны тоног төхөөрөмжийн зардалд 19.5 сая, цалинд 10.0 сая, тавилга эд хогшилд 9.8 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. | |
| 248 | | 4.1.10.2. Иргэд олон нийтэд мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн, аймаг, орон нутгаас тодорсон алдартан гавьяатан, шинийг санаачлагч, баялаг бүтээгчдийг алдаршуулах | Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо-1000 | Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо | | Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо-2000 | 2023 онд аймгийн Засаг даргаас төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, орон нутаг дахь сэтгүүлчидтэй нийт 75.900.000 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулж, төрийн ажил үйлчилгээг сурталчиллаа. Давхардсан тоогоор нийтдээ 1660 удаагийн мэдээллийг нийтэд түгээж ажилласан. Мэдээллийн нийт хандалт 1.509.144 байна.. МҮОНТ-тэй хамтран “Агуу түүх Алтанбулагаас” нийтлэл уран сайхны нэвтрүүлэг /1 цаг/, “Шивээ Хиагт” теле дуурь /1 цаг 30 минут/, “Цэнгэлийн манлай” /30 минут/, “Ардын хувьсгалын чацуутан” хөрөг нэвтрүүлэг /20 минут/ , “Нутагтаа сайхан амьдаръя” Шаамар сумын Дулаанхаан тосгоны өрхийн аж ахуйтан Д.Отгонбаяр /20 минут/, “Аялалын тойрог” нэвтрүүлгийн продюсер Ц.Ган-Өлзийтэй хамтран 17 сумын байгалийн үзэсгэлэнт газар нутаг, хүн зоны ажил амьдрал, өрхийн үйлдвэрлэгчид, орон нутгийн онцлог давуу талыг харуулсан тус | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүр 50 минутын 5 удаагийн дугаарыг бэлтгэн UBS, Өлзий, E-TB, ТВ-6, Малчин, Оргил телевизүүдийн эфирээр 2-3 удаагийн давтамжтайгаар гаргаж олон нийтэд сурталчлан аялагч жуулчдыг уриалан дуудлаа. “Тэйк оф” ХХК-ийн захирал Д.Баясгалантай хамтран 17 сум, 6 тосгоны шилдэг өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдээ “Сумандаа сайхан амьдаръя” зорилтот нэвтрүүлгээр алдаршууллаа. “Номайдик энтертейнмент”ХХК-тай хамтран Сэлэнгэ аймгийг илтгэн харуулах түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газруудын фото зургийг бэлтгэлээ. Мөн төр түмэндээ үнэлэгдсэн баялаг бүтээгч шинийг санаачлагч хөдөмөрийн сайчуудын 29 удаагийн ярилцлага, нийтдээ 61 удаагийн нэвтрүүлэг, ярилцлага бэлтгэн Сэлэнгэ аймгийнхаа баялаг бүтээгчдийг алдаршуулах, нутаг орноороо бахархах, аялагч жуулчдыг урин дуудаж соён гэгээрүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. | |
| 249 | 4.1.11. Төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр, ажил үйлчилгээний | 4.1.11.1. Орон нутгийн телевиз, цахим сайт, сонины удирдлагуудтай хамтран тойм мэдээллийг | Жилийн хамтран ажиллах гэрээ 14.3 төгрөг | Бэлтгэсэн мэдээллийн тоо | | Бэлтгэсэн мэдээллийн тоо-24 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаас аймгийн хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа цаасан суурьт хэвлэл болох “Сэлэнгийн мэдээ” сонины дугаар бүрд аймаг орон нутгийн онцлох | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “СЭЛЭНГЭ ТОЙМ” мэдээ, мэдээллийн хөтөлбөртэй болж, цаасан суурьт болон цахим сэтгүүлээр дамжуулан сурталчилна. | тогтмолжуулах ажлыг зохион байгуулах | | | | | ажил арга хэмжээг багцалсан “Сэлэнгэ тойм” мэдээллийг тогтмол гаргаж хэвшүүлсэн. Тайланд хугацаанд тус сонины 11 удаагийн дугаарт 200 гаруй багц мэдээллийг гаргалаа. Орон нутгийн бусад пейж, орон нутаг дахь сэтгүүлчид өөрсдийн сувгуудаар “цаг үе-үйл явдал” хэлбэрээр мэдээллийг олон нийтэд түгээн хамтран ажиллаж байна. | |
| 250 | | 4.1.11.2. Аймаг, орон нутгийн цаг үеийн мэдээ мэдээллийг цаасан суурьт хэлбэрээр нийтэд танигдсан “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлээр үргэлжлүүлэн гаргаж нийтэд сурталчлах | 2000 ширхэг сэтгүүл | Цаасан суурьт болон цахим хэлбэрээр сэтгүүлийн тоо | | Цахим болон цаасан суурьт сэтгүүлийн тоо- 6000 | Төр төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимд шилжсэн энэ хугацаанд төрийн ажил үйлчилгээний мэдээ мэдээлэл бүхий “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлийн 1 удаагийн дугаарыг 1000 ширхэгээр бэлтгэн гаргаж иргэд олон нийтэд түгээсэн. Сэтгүүл А4 хэмжээ, 100 нүүртэйгээр бэлтгэгдсэн. Аймаг орон нутгийн мэдээллийн цаасан суурьт хэвлэл болох “Ургадаг алт” сэтгүүлийн 4 удаагийн дугаарт, орон нутгийн онцлог давуу тал, брэнд бүтээгдэхүүн, эдийн засгийн үзүүлэлт, баялаг бүтээгчдийн төлөөлөл, аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын даргын ярилцлагыг “Монголын үнэн”, “Зууны мэдээ” сонинтой хамтран тусгай дугаараар гаргаж олон нийтэд түгээсэн. Masam II төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн 2023 оны батлагдсан төсвийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмхэтгэл бүхий “Иргэдийн төсөв” гарын авлагыг цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилж таниулах ажлыг хамтран гүйцэтгэсэн. | |
| 251 | 4.1.12. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоо, мэргэжлийн байгууллагын бэлэн байдлыг ханган, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлж, шаардлагатай сумдад онцгой байдлын тасаг нэгжийг байгуулна. | 4.1.12.1. Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах | 2014 онд зохион байгуулагдсан | Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд хамрагдсан иргэд, байгууллага, ААН-ийн тоо | | - | Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Аймаг, нийслэлд гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах хуваарь, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж 17 сум, 6 тосгоны 143 аж ахуйн нэгж, байгууллагын 386 удирдах албан тушаалтан, 1933 ажилтан, төр захиргааны байгууллагын ажилтан, албан хаагч, 2373 ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагч, 3458 иргэн нийт 8150 хүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Мөн 2022 оны 6 дугаар сарын 5-ны өдөр гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллаж аймгийн хэмжээнд 32,320 иргэн түр цугларах талбайд цугларч сургуулийн удирдагчаас “Дүүрэн хангалттай” үнэлгээ авч ажилласан. Стратегийн команд штабын сургуулийн хүрээнд гамшгийн аюулын тухай дадлага сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16 цагт зохион | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулж, нийтдээ 14375 иргэн хамрагдсан. | |
| 252 | | 4.1.12.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулах | 65 удаа | Гамшгаас урьдчилан сэргийлэх зохион байгуулсан сургалт сурталчилгааны тоо | | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг ур чадвар дээшилнэ. | Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах, таниулах, болзошгүй гамшиг осол, гал түймрийн үед өөрийгөө болон бусдын амь насыг аврах, урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үзүүлэх зэрэг нийт 67 сэдэв, 201 цагийн хичээл бэлтгэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2021 онд 60 удаа танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж 1031 удирдах бүрэлдэхүүн, ажилтан алба хаагч, сайн дурынхан, иргэд, оюутан сурагчдыг, 2022 онд 318 удаа 7671 хүнийг хамруулан танхимын болон дадлага сургалт зохион байгуулж, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтний удирдлагын систем surtgalt.nema.gov.mn цахим хуудсанд сургалтуудыг бүртгэж ажилласан. 2023 онд иргэд, олон нийтийг гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг олгох 117 цагийн дадлага сургуулийг ерөнхий боловсролын сургуулийн 92 сурагч, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн 1347 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажилтан, алба хаагчдын дунд зохион байгуулсан. | |
| 253 | | 4.1.12.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, хяналт шалгалт зохион байгуулах | 56 байгууллагад хяналт шалгалт зохион байгуулсан | Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, хяналт шалгалт зохион байгуулсан тоо | | сум орон нутаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн эрсдэл эмзэг байдал буурна. | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын “Календарчилсан төлөвлөгөө”, аймгийн Засаг даргын 2022 оны “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг хангах тухай” А/52, “Хуваарь батлах тухай” А/53 дугаар захирамжаар нийт 17 төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт төлөвлөгдөж, удирдамжийн хүрээнд 412 объект, 2851 айл, өрхийг хамруулж 2885 зөрчлийг илрүүлж 978 зөрчлийг шалгалтын явцад арилгуулан гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 172, мэдэгдэл 312, танилцуулга 9, зөвлөмж 168-ыг тус тус үйлдэн холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, 2684 зөрчлийг арилгуулсан биелэлт 93 хувьтай дүгнэгдсэн. 2023 оны “Хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/154 дүгээр захирамжаар томилогдсон Онцгой байдлын газрын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрүүдэд 17 сум, 6 тосгонд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, 408 ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор “Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ”, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний индикаторын аргачлал”, “Гамшгийн эрсдэлийн ба хөгжил” сэдэвт 34 цагийн танхимын сургалт, 102 цагийн дадлагыг зохион байгуулан ажилласан. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтаар нийт 84 байгууллагын 100 объект хамрагдсанаас галын аюулгүй байдлын хуулийн этгээдийн үүргийн хэрэгжилтийн зөрчил 670-г илрүүлэн, газар дээр нь 4 зөрчлийг арилгуулан, улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 82, мэдэгдэл 2, ажиллагаа зогсоох тогтоол 7-г үйлдэн, байгууллагын дарга, эрхлэгч нарт гардуулан, заавар, зөвлөгөө өгсөн. | |
| 254 | | 4.1.12.4. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, зөвлөмжийг түгээх ажлыг зохион байгуулах | 1200 удаа төрөл бүрийн сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг түгээсэн | Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл, | | Сум орон нутаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн эрсдэл эмзэг байдал буурна | Гамшгаас хамгаалах болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 40 төрлийн сэрэмжлүүлэг шторк бэлтгэж байгууллагын болон Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны цахим хуудсанд байршуулан нийт хандалтын тоо 74,500 хүрсэн байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөмж түгээсэн тоо | | | Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизээр 8290 удаа сэрэмжлүүлэг, шторк гаргаж 82 удаа ярилцлага өгч, Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд 245 удаа урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийг иргэд олон нийтэд түгээсэн. Гамшгаас хамгаалах талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, Онцгой байдлын албаны үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах, иргэдэд болзошгүй аюулослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилгоор “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийн 52 удаагийн дугаарыг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэн ажилласан. /Хандалтын тоо 107,125 хүрсэн байна/. Мөн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, гэр хорооллын айл өрхүүдэд гарч буй гал түймрийн дийлэнх шалтгаан нөхцөлийг судлан “Гал түймрийн шалтгаан нөхцөл” сэдэвт цуврал шторк бэлтгэн цахим сүлжээг ашиглан сурталчлан ажиллахад хандалтын тоо 67,000 хүрсэн байна. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон Онцгой байдлын газар, хэлтэс, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | анги салбарын авч хэрэгжүүлж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн 2023 оны жилийн эцсийн байдлаар Онцгой байдлын газрын sea.nema.gov.mn цахим хуудсанд 217 удаа, facebook.com/selengeobg олон нийтийн сүлжээнд 297 мэдээ, 181 сэрэмжлүүлэг нийт 695 удаа байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан түгээж ажилласан. | |
| 255 | 4.1.13. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зөвлөн туслах үйлчилгээ, сургалт, тандалт, хяналт шинжилгээний арга хэлбэртэй хослуулах, эрсдэлийн судалгаа, баазыг эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлнэ. | 4.1.13.1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх, ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах | 2020 онд 5616 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт шалгалтад нийт 360, ЗТҮ-нд 114 объектыг хамруулсан. 2021 онд нийт 5368 объектод эрсдэлийн үнэлгээ хийж иргэд аж ахуй нэгжүүдэд Шилэн хяналтын цахим системээр дамжуулан зарласан. 2020 онд 5616 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх, ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах | - | Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, “Шилэн хяналтын цахим систем”-д 2023 оны эрсдэлийн үнэлгээг бүртгэж, эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтаар нэгдсэн цахим санг бүрдүүлнэ. | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, тээвэр, авто зам, эрчим хүч, харилцаа холбоо, уул уурхайн чиглэлээр 315 объектод эрсдэлийн үнэлгээ хийхээр төлөвлөснөөс 174 объект их эрсдэлтэй, 151 объект дунд эрсдэлтэй үнэлэгдэж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажилласан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгалтад нийт 360, ЗТҮ-нд 114 объектыг хамруулж, гүйцэтгэл 100 хувьтай. | | | | | |
| 256 | | 4.1.13.2. Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалт хийх | 2020 онд төлөвлөсөн объектуудын 100 хувь хамруулсан байна. | Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт, шалгалт хийсэн хувь | - | Эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. | Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн төлөвлөгөөт хяналт шалгалтад 63 объектыг хамруулахаар төлөвлөснөөс 56 объекыг шалгалтад хамруулж, 301 зөрчлийг илрүүлэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 56 аж ахуй нэгжид 273 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж, аж ахуй нэгжид улсын байцаагчийн акт 3, дүгнэлт 9 гарган холбодох байгууллагад хүргүүлэн, зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн болох нь тогтоогдсон 4 иргэн, 12 аж ахуй нэгжид зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж нийт 12.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийн хэрэг бүртгэлтийн материалыг аймгийн Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хянуулан ажилласан. | 100% |
| 257 | | 4.1.13.3. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх | 2020 онд зөвлөн туслах үйлчилгээнд хамруулахаар 114 | Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг | - | "Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан хууль сахин | 40 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 242 заалт бүхий 40 зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтэд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | объектыг төлөвлөснөөс нийт 114 объектыг шалгалтад бүрэн хамруулж төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангуулсан. | бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн тоо | | мөрдөлтийн түвшинг 7 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. Зөвлөмжийн биелэлтийг 7 хувиар нэмэгдүүлнэ.Объектын эрсдэлийн түвшинг 7 хувиар бууруулсан байна. - Шилэн хяналтын цахим мэдээллийн санд мэдээллийг бүрэн оруулж, гүйцэтгэл, үр дүнг тооцож ажилласан байна. " | хяналт тавьж ажиллаж, объектын эрсдлийн түвшин 10 хувиар буурсан. | |
| 258 | 4.1.14. Сумдын хилийн цэсийн асуудлыг шат, шатны байгууллагуудад уламжилж, хот төлөвлөлтийн өргөжин тэлэх боломжийг бүрдүүлэх | 4.1.14.1. Сумдын хилийн цэсийн асуудлыг шат, шатны байгууллагуудад уламжилж, хот төлөвлөлтийн өргөжин тэлэх боломжийг бүрдүүлэх | - | Сумдын хилийн цэсийн асуудлыг шат, шатны байгууллагууда д уламжлан шийдвэрлэж өргөжин тэлэх боломжийг бүрдүүлсэн эсэх | - | Хилийн цэсийн гадна олгогдсон зөрчилтэй нэгж талбаруудын судалгааг, сум тус бүрээр гаргаж зөрчил арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлж, хот төлөвлөлтөд тусгасан байна. | Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Дархан уул аймгийн Хонгор сумын хил цэс, Сэлэнгэ аймгийн Баянгол сум Төв аймгийн Жаргалант сумын хилийн цэс, Сант, Баруунбүрэн сумдын хилийн цэсийн асуудлыг холбогдох шат, шатны байгууллагуудад уламжилан хот төлөвлөлтийн өргөжин тэлэх боломжийг бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 259 | 4.2.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах бодлогын баримт бичиг боловсруулан хэрэгжүүлнэ. | 4.2.1.1.. Бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулж, бодлогын баримт бичгийг аймгийн ИТХ-аар батлуулах | 3 | Бодлогын баримт бичгийн тоо | | Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлсэн байна. | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах аймгийн бодлогыг 5 бүлэг 10 бүрэлдэхүүн хэсгийн 67 арга хэмжээтэйгээр боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, 2021-2023 онуудад жил бүр төлөвлөгөөг батлуулж, тайланг хагас, бүтэн жилээр гарган Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж ажилласан. | 100% |
| 260 | | 4.2.1.2. Алтанбулаг, Сүхбаатар боомтод Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтарсан Команд штабын сургуулийг зохион байгуулах | - | Зохион байгуулагдсан Команд штабын сургуулийн тоо | | Сүхбаатар боомтод КШС-ийг зохион байгуулсан байна. | Сүхбаатар боомтод Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтарсан Команд штабын сургуулийг зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдсан болович тайлант онд хэрэгжээгүй бөгөөд Алтанбулаг, Сүхбаатар боомтод 2024 онд Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтарсан Команд штабын сургуулийг зохион байгуулахаар төлөвлөж байна. | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 261 | 4.2.2. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай хүргэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ | 4.2.2.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх хандлага, дадлыг төлөвшүүлэх, “Эрх зүйн боловсролыг иргэн бүрт” нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2020 онд нийт давхардсан тоогоор 14357 иргэний танхимын болог цахим сургалтад хамруулж нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. | Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | | Аймгийн хэмжээнд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцсон байна. | Аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр захиргааны шийдвэр хянах, хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, хуваарийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж, 2021-2023 онд 107,201 иргэд, төрийн албан хаагчдад хууль, эрх зүйн албан болон албан бус сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны ой”-г жил бүр тэмдэглэн сургалт, сурталчилгааны болон шатар сонирхогчдын дунд шатрын тэмцээнийг тогтмолжуулж, Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг иргэд олон нийтэд сурталчилж, шинээр хэрэгжиж буй хуулиудаар Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 3 удаагийн сургалтыг зохион байгуулж 110 төрийн албан хаагчийг хамруулсан. “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллагатай хамтран “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийг болон төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх мониторинг хийх зорилгоор “Миний мэдэх эрх” | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтыг төрийн албан хаагчид, иргэний нийгмийн төлөөлөл, сэтгүүлч хэвлэл мэдээллийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан. “Хуулийн өдөр” арга хэмжээг 2022-2023 онд 15 сум, 6 тосгонд зохион байгуулж, Авлигын эсрэг хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, орон нутгийн төрийн байгууллагуудын архивын үйл ажиллагаатай танилцаж, 28 байгууллагын архив, албан хэрэг хариуцсан ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, ”Баримт бичиг зохион бүрдүүлэх“, “Байгууллагын архивын ажлын зохион байгуулалт”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх тухай”, “Архивын баримтад тооллого хийх” тухай сургалтыг тус тус зохион байгуулж нийт 233 албан хаагчийг хамруулсан. | |
| 262 | | 4.2.2.2. Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр | Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол 21, аймгийн Засаг даргын 3 захирамжийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн хүчин төгөлдөр | Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар | | Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийг хуульд нийцүүлэн батлуулж | “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 32 тогтоол, аймгийн Засаг даргын 2 захирамж бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2022 онд газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын заагт, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тайлбарлан таниулах ажлыг тогтмол хийх | мөрдөж ажилласан. | бүхий шийдвэрийн тоо | | Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхэд зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна. | хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолуудыг хүчингүй болгож, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, legalinfo.mn цахим системээс хасуулах ажлыг зохион байгуулсан. 2023 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарын шинэчлэн тогтоох тухай” А/02 дугаар захирамж, Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 53 дугаар, Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 131 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Хог хаягдлын үнэ тариф батлах тухай” захиргааны хэм хэмжээний актыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. | |
| 263 | | 4.2.2.3. Хууль, тогтоомж сурталчлах, зөвлөгөө өгөх “Эрх зүйн хөтөч”-ийг багуудад ажиллуулах асуудлыг судлан, сургалт, сурталчилгааны ажлыг иргэдэд хүртээмжтэй, | 57 эрх зүйн хөтөч | Бэлтгэсэн эрх зүйн хөтчийн тоо | | Сар бүр 1-ээс доошгүй удаа, жилд 12 удаа эорх зүйн хөтөч нарыг давтан сургалтанд хамруулж, сургалт, сурталчилгааны | “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх зүйн хөтөч нарыг үйл ажиллагаа явуулахад нь удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах талаар аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжилтийг хангаж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ойлгомжтой байдлаар зохион байгуулах | | | | ажлыг нэмэгдүүлсэн байна. | ажилласан. Хууль тогтоомж сурталчлах зөвлөгөө өгөх эрх зүйн хөтчийн нэгдсэн мэдээллийг шинэчлэн, эрх зүйн хөтөч нарыг давтан сургах сургалтыг 2021 онд, Ханнс Зайделийн сан, Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй хамтран 2022 онд “Эрх зүйн хөтчийн чадавхжуулах” сургалтад, 17 сум, 6 тосгоны 45 Эрх зүйн хөтчийг, эрх зүйн хөтчийг чадавхжуулах цахим сургалтад 17 эрх зүйн хөтөч, Үндсэн хуулийн дугуйлан төслийг үргэлжлүүлэхээр 45 сургагч багш тус тус бэлтгэгдсэн. | |
| 264 | 4.2.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана | 4.2.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг танхимаар болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулах | 14 аж ахуйн нэгж байгууллагын 290 иргэн | Хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган зохион байгуулсан байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн албаны 2 тээврийн хэрэгсэлд суурилуулах тусгай дуу, гэрэл бүхий тоноглолын 840.0 мянган төгрөгийг, аймгийн Цагдаагийн газраас “Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлье” тусгай арга хэмжээний хүрээнд 602.400 төгрөгийг Ерөө сумын, “Зөвийг зөвлөе” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 820.000 төгрөг Мандал, Сүхбаатар сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс тус тус шийдвэрлүүллээ. 2022 онд гэмт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 39 арга хэмжээ, сурталчилгааны 35 хулдаасан хэвлэл, самбарыг, 2023 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 33 арга арга хэмжээг аймгийн цагдаагийн газар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт 147, уулзалт 4, өдөрлөг 8, тэмцээн уралдаан 2 удаа зохион байгуулаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 227.0 сая төгрөгийг, “Анзаар” арга хэмжээнд 2.5 сая төгрөгийг, "Замын хөдөлгөөний цагаан толгой-2023" тэмцээнд 4.7 сая төгрөг, нийт 35.091.600 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн ажиллалаа. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд малчдын оролцоо” нэг бүрчилсэн арга хэмжээний хүрээнд 200,0 мян төгрөг, сураггүй алга болсон иргэнийг эрэн хайх ажиллагаанд шаардагдах 4.0 сая төгрөг, Сайхан сумын камер засварлахад шаардагдах 4.3 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. Ерөө сумын Бугант тосгонд MNS | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2019:6423 стандартын шаардлага хангасан 7 чиглэлд 19 хяналтын камерийг суурилуулахад орон нутгийн төсвөөс 18.6 сая төгрөгийг, хуулийн этгээдээс 12.8 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 726 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 43 хэргээр буюу 6.3 хувиар буурсан байна. | |
| 265 | | 4.2.3.2. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн болон холбогдох байгууллагуудын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | 2020 онд 549 гэмт хэрэг бүртгэгдсэн. | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | | Гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үеэс 3 хүртэл хувиар бууруулсан байна | Тодорхой төрлийн гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий 27, тусгай 10, соён гэгээрүүлэх 2 нийт 39 арга хэмжээг зохион байгуулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг Хууль зүй дотоод хэргийн сайдтай хамтран ажиллах гэрээ, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ болон аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж, 2022 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 153 удаагийн сургалтад 106 байгууллага, аж ахуйн нэгжийн 9939 иргэн, 2023 онд нийт 154 удаагийн удаагийн сургалт, өдөрлөгийн арга хэмжээнд давхардсан тоогоор 283 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллага, аж ахуйн нэгжийн 8678 иргэнийг тус тус хамруулсан | |
| 266 | 4.2.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээн авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвлшүүлнэ. | 4.2.4.1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн албан хаагчдад танхимын болон цахим сургалтууд, зөвлөгөө дэмжлэг өгөх ажлыг зохион байгуулах | Аймгийн шударга байдлын үнэлгээ 2019 онд 77.0 оноогоор үнэлэгдсэн. | Аймгийн шударга байдлын үнэлгээний индекс | | 75 хувь | 2021 онд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн нь тогтоогдсон 1, 2022 онд 2, 2023 онд 1 албан тушаалтанд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож, дээрх зөрчлийг дахин гаргуулахгүй байх, сумын төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. 2021 онд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг аймгийн Гаалийн газрын улсын байцаагч, Алтанбулаг сумын нийт төрийн албан хаагч нарт цахим хэлбэрээр, 2022 онд Авлигатай тэмцэх газартай хамтран “Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт 24 агентлагийн 90 төрийн албан хаагч, 8 багийн 140 иргэн, 6 сургуулийн 287 сурагчд, 17 сум, 24 агентлагт “Авлигын эсрэг хамтдаа” сэдэвт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад 325 албан хаагчийг, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран 4 удаагийн сургалтаар 86 төрийн албан хаагчийг, 2023 онд Авлигатай тэмцэх газартай хамтран ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажлыг хангах тухай ЭБАТ-уудад зориулсан сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, 22 эрх бүхий албан тушаалтныг хамрууллаа. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 8 сум, 3 тосгон, 12 байгууллагад зохион байгуулсан 24 удаагийн сургалтад нийт 1012 албан хаагчийг тус тус хамруулан ажиллалаа. Авлигатай тэмцэх газраас гаргадаг “Шударга байдлын үнэлгээ”-нд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар 2023 онд 72.2 оноотойгоор дүгнэгдэж өмнөх оныхоос 10 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Судалгаанд аймгийн Засаг даргын Тамгын газраар үйлчлүүлсэн иргэд болон шинжээч нар нийтдээ 250 хүн хамрагдлаа. | |
| 267 | | 4.2.4.2. Олон нийтийг соён гэгээрүүлэх шударга ёсны тогтолцоог төлөвшүүлэх | 70 орчим контентуудыг 22 агентлаг, 17 сум, 6 тосгодод иргэд, олон нийтэд | Бэлтгэсэн сурталчилгааны материалын тоо | | 90 хувь | Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Шударга удирдагч, шударга төрийн албан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чиглэлээр бэлтгэсэн видео шторк, контент, зураг хуудас зэргийг бэлтгэн нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах | хүргэн, нийт 889 иргэнд 1000 гаруй тараах материалыг олгон соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. | | | | хаагч” аян зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжаар аяныг жил бүр өрнүүлж ажиллалаа. Аймгийн нийтийн номын сан болон байгууллагын номын санд “Албан тушаалын гэмт хэргийн Шүүхийн шийдвэрийн 2011-2017 оны эмхэтгэл”-үүд, “Зөв зөвд ШУДАРГА ЗӨВ”, “Үнэт зүйлийн боловсрол”, “Монгол Улсын Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилт, тойм танилцуулга”, хувийн хэвшилд зориулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмж”, “Шударга ёс, хөгжил дэвшилд-Хувийн хэвшлийн оролцоо” зэрэг ном, гарын авлага, зурагт хуудсуудыг байршуулан нийтийн хүртээл болголоо. Мөн аймгийн 17 сум 6 тосгон, 24 агентлагт “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” гарын авлагуудыг тус тус олгосон. Авлигатай тэмцэх газартай хамтран аяны нээлтийг аймгийн нийт төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж, Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалтыг цахимаар 2 удаа, танхимаар 18 удаа, мөн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Авлигын эсрэг хамтдаа” сургалтыг тус тус зохион байгуулж, сургалтад 1120 албан хаагчийг хамрууллаа. Шил ажиллагааны хүрээнд shilen.gov.mn цэсэнд хуулийн төсөл болон захиргааны хэм хэмжээний актад өгсөн санал, тэдгээрийн танилцуулга, Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, 2022, 2023 онд шинээр томилогдсон албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай дүгнэлт, байгууллагын эзэмшиж буй оюуны өмчийн эрхийн жагсаалт, Авлигын эсрэг хууль тогтоомж сурталчилсан видео шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном зэргийг аймаг, сумдын албан ёсны цахим хуудсаар болон төв талбайн лед дэлгэцээр дамжуулан нийтэд хүргэж, 1000 гаруй гарын авлагыг иргэд, төрийн албан хаагчдад тараан олгож ажилласан. | |
| 268 | | 4.2.4.3. Авлигатай тэмцэх үндэсний болон аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх олон талт | 2019 онд хариуцлага тооцуулсан ТАХ байхгүй | Хэрэгжилтийн хувь | | 82 хувь | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2022 оны биелэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 95.7 хувийн үнэлгээтэйгээр тайлагнасан. Авлигын эсрэг хууль тогтоомжийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажил, арга хэмжээг зохион байгуулах | | | | | сурталчлах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулах, төсөлд олон нийт, сонирхогч бүлгийн санал, хүсэлтийг авах болон иргэд, аж ахуй нэгжээс санал, өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах боломжийг бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуй нэгжийн жагсаалт, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үнэ тарифын талаарх мэдээллийн хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлэх, мэдээллийн баяжилт болон тасралтгүй ажиллагааг хангаж тухай бүр шуурхай байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг “Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай” захирамжаар сум, агентлагийн удирдлагуудад үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан. Авлигатай тэмцэх газартай хамтран “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлье” соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт 24 агентлагийн 90 төрийн албан хаагч 8 багийн 140 иргэн, 6 сургуулийн 287 сурагчдыг хамрууллаа. Авлигатай тэмцэх газраас “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай”, болон “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар” ирүүлсэн нийт 14 мэдэгдэл, албан тоотуудын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны “Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай” 01/905 дугаартай албан тоот, Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2022 оны “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 01/1196, 01/1197 дугаартай албан тоотуудыг тус тус гарган сумд, агентлагуудад хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан. 2023 оны байдлаар үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаагүй. | |
| 269 | 4.2.5. Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан | 4.2.5.1. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2020-2023 оны төлөвлөгөөг | 74 | Хэрэгжилтийн хувь | | 90 хувь | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2019-2023 оны төлөвлөгөөг 15 зорилтын 95 ажил, арга хэмжээтэйгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | Тэргүүлэгчдийн Хурлын 2020 оны 05 дугаар тогтоолоор батлуулан, сум агентлагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. "Хүний эрхийн төлөө" аймгийн Засаг даргын 2021 оны "Олон улсын "Хүний эрхийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай А/373 дугаар захирамжийг батлуулан Хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төв болон аймагт үйл ажиллагаа явуулдаг хууль сахиулах байгууллагуудтай хамтран "Хүний эрхийн өдөрлөг" арга хэмжээг "Хөдөлмөрлөх эрхийн тухай ярилцъя" нээлттэй уулзалтыг зохион байгуулж иргэдэд хууль сурталчилан, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2020-2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор шинээр батлагдсан хууль, тогтоомжийн болон хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтыг Алтанбулаг, Шаамар, Баруунбүрэн, Орхон, Орхонтуул, Сант, Сүхбаатар, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдын 258 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэд, төрийн албан хаагчдын дунд зохион байгууллаа. | |
| 270 | | 4.2.5.2. Хүний эрхийг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн төлөө хамтдаа аяныг зохион байгуулах | 17 сум, 22 агентлагт Хүний эрхийн төлөө хамтдаа аян зохион байгуулсан. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | - | Хүний эрхийн Үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл хамтран “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад 60 албан тушаалтныг хамруулан ажилласан. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2012-2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах санал, 2018-2022 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний талаарх мэдээллийг аймгийн хэмжээнд нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. Хүний Эрхийн Үндэсний Комиссын ороннутаг дахь референттэй хамтран Баруунбүрэн, Сант, Орхон, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Орхонтуул, Шаамар, Алтанбулаг сумдад Хүний эрхийн сургалт зохион байгуулж, 170 гаруй иргэд, төрийн албан хаагчийг хамруулан ажилласан. Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн шаардлагын дагуу Сүхбаатар, Сант сумдын албан тушаалтнуудын үйл ажиллагаанд шаардлагад дурдагдсан хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамтаас ангид байх эрх зөрчигдөхөд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах гомдлын мөрөөр тус тус ажиллаж, хариуг хүргүүлж ажилласан. | |
| 271 | | 4.2.5.3. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг жил бүр зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 80 хувь | Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлсэн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд аймгийн Цагдаагийн газрын дэргэд 219 мкв бүхий “Түр хамгаалах байр”-ны барилгыг бүрэн засварлан тохижууллаа. 2022 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж өмнөх оноос 5 хэргээр буюу 45.5 хувиар өссөнтэй холбогдуулан энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Зөвийг зөвлөе”, “Намайг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | алгас” нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг дэлгүүр, зочид буудал, баар, ресторан, караоке зэрэг 54 аж ахуй нэгжийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөх, иргэд, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 2022 онд 4 удаа, хороогоор дамжуулан 11 хүүхдэд, 2023 онд гэмт хэрэгт холбогдсон 6 хүүхдэд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө дэмжлэгийг үзүүлэн ажиллалаа. Аймгийн Цагдаагийн газраас бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан сумдад 35 удаагийн сургалтаар 4824 хүүхэд, иргэдийг бэлгийн хүчирхийллээс | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрхэн урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар яриа таниулга хийж, энэ талаарх мэдээллийг хэнд хэрхэн өгөх талаар зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар хүүхэд оролцсон гэмт хэрэг 49 бүртгэгдэж 12 нэгжээр буюу 32.4 хувиар өссөн, бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэрэг бүртгэгдээгүй эерэг үзүүлэлттэй байна. | |
| 272 | 4.2.6. Стандарт шаардлагад нийцсэн төрийн архивын барилга барих ажлыг үе шаттай шийдвэрлэнэ. | 4.2.6.1. Барилгын зураг төсөв хийлгэх төсвийг шийдвэрлүүлэх | Архивын байргүй | Арга хэмжээний тоо | | - | Зураг төсвийн “ОСИБ ЗТ” ХХК-тай хамтран архивын барилгын зураг, төсвийн төслийг боловсруулан ХЗДХЯаманд хүргүүлсэн. Төрийн архивын барилгын эх загвар зургийг аймгийн ерөнхий архитектороор батлуулж, зураг төсвийн “ОСИБ ЗТ” ХХК-иар Архивын барилгын угсралтын ажлын төсвийг хийлгүүлэхээр саналыг хүргүүлэн ажилласан. | 70% |
| 273 | 4.2.7. “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн улсын бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломж нөхцлийг | 4.2.7.1. Улсын бүртгэлийн салбарт ашиглагдаж байгаа мэдээллийн баазыг өргөжүүлэх замаар иргэдэд үзүүлэх цахим | Цахимд сан сумдыг холбосон. | нэмэгдсэн цахим үйлчилгээний тоо | | Үйлчилгээний шинэ төрлийг иргэдэд хүргэж эхэлсэн байна. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан 22 төрлийн лавлагаа, 50 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс аймгийн хэмжээнд иргэний бүртгэлийн 26 төрлийн үйлчилгээ, 12 төрлийн лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 13 төрлийн үйлчилгээ, 7 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сумдад бүрдүүлнэ. | үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх | | | | | төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээ, 3 төрлийн лавлагааг тус тус цахимаар үзүүлж ажиллалаа. Эдгээрээс 27 үйлчилгээ нь шуудан хүргэлтээр хийгдэж байна. “Бүртгэлийн Киоск” төхөөрөмжийг Алтанбулаг боомтод байршуулж, Хаан банктай хамтран ажиллах гэрээний дагуу Мандал, Сайхан сумд болон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний байранд Хаан банкнаас нэгж бүр нь 30.0 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг киоск машиныг бүртгэлийн байгууллагад зориулан хөгжүүлэлт хийн суурьлуулж иргэдэд үйлчилж байна. Мөн Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Сайхан сумд болон лавлагаа үйлчилгээний улсын бүртгэгч нарт 5 ширхэг пос төхөөрөмжийг байршууллаа. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газраас 22 төрлийн лавлаа, 68 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Улсын бүртгэлийн байгууллага Засгийн газрын 2020 оны “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 230 дугаар тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн ба тус тогтоолоор лавлагааг үнэ төлбөргүй авах болсон нь иргэн, хуулийн этгээдээс гарах зардал хэмнэгдэж боломж бүрдсэн. Тус системээр дамжуулан шаардлагатай цаасан нотлох баримт бичгийг шуудангаар хүлээн авч, бүртгэгдсэн бичиг баримтыг буцаан хүргүүлэх зорилгоор Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар, Монгол шуудан ХК-тай хамтран нэг талт болон хоёр талт шуудангийн үйлчилгээг нэвтрүүлсэн. | |
| 274 | | 4.2.7.2. Иргэний тоон гарын үсгийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлэх | Тоон гарын үсэг нэвтрээгүй. | Хэрэгжилтийн хувь | | Иргэд тоон гарын үсгээ ашиглан бүртгэлийн үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна. | Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тоон гарын үсгийг олгох ажлыг эрчимжүүлэх, иргэдэд сурталчлан таниулах зорилгоор хэлтсийн даргын 2022 оны 07 дугаар тушаалаар төрийн байгууллагууд болон орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар, боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд, багийн иргэдийг хамруулах хуваарь гаргаж, нийт 84 байгууллагын 10914 албан хаагчдад тоон гарын үсгийг олгосон байна. Иргэдэд тоон гарын үсэг олгох, тоон гарын үсгийн хэрэглээг сурталчилан таниулах ажил өдөр бүр хэрэгжиж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 73,802 иргэнээс | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 27,948 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. | |
| 275 | | 4.2.7.3. ГЗБГЗЗГ-тай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болох | Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас дундын мэдээллийн сангаар дамжуулан газар, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаар олгох талаар нийт 7837 бүртгэл хийсэн байна | Бүртгэгдсэн мэдээллийн тоо | | Хаягжуулалтын журмын хүрээнд хаяг шинэчлэгдсэн иргэний цахим үнэмлэх, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /хаяг/ солих ажлыг зохион байгуулна. | Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж зам талбай үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах" журмын хэрэгжилтийн хүрээнд аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн кадастарын мэдээллийн сангийн лавлагаа мэдээлэлтэй тулгаж үл хөдлөх хөрөнгийг шинээр хаягжуулах ажлыг зохион байгуулж 2022 онд 2797, 2023 онд 3207 өмчлөх эрхийн бүртгэлд хаягийн өөрчлөлтийг тусгасан. | 100% |
| 276 | 4.2.8. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг шинэчилж хил хамгаалах албыг бэхжүүлэн, хил хамгаалах байгууллагуудын нэг цонхны | 4.2.8.1. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, албаны бэлэн байдлыг хангах ажилд дэмжлэг үзүүлэх | 100 хувь | Үзүүлсэн дэмжлэгийн тоо | | 70 хувь | Монгол Улсын Хилийн тухай хуулийн дагуу “Хилийн бүсийн өргөнийг шинэчлэн тогтоох тухай” 2021 оны Хил хамгаалах ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар улсын хилийн бүсийн өргөн, түүний зааг, эргэлтийн цэгүүдийг шинэчлэн баталсан. Хилийн 0243 дугаар ангийн цэргийн байр, эмнэлгийн байрыг улсын төсвийн 1 тэрбум 115 сая төгрөгөөр 2023 онд бүрэн барьж ашиглалтад оруулсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 277 | үйлчилгээний байрыг ашиглалтад оруулна. | 4.2.8.2. Баруун хужир, Хар горхи, Цөхийн заставт ажиллаж буй хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах | Нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлсэн. | Үзүүлсэн дэмжлэгийн тоо | | Хилчдийн нийгмийн баталгаа хангагдсан байна. | Хилийн 0284 дүгээр салбар Хар горхийн хилийн заставт 6 айлын нэгдсэн халаалттай байр барьж 2021 оны 07 дугаар сард ашиглалтад оруулсан. Хилийн 0281, 0284, 0283 дугаар салбар (Баруун хужир, Хар горхи, Цөх)-уудад ажиллаж байгаа офицер, ахлагч нарын хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор байгууллагаас улирал тутам 420.000 төгрөгийн тэтгэмж олгосон. Монгол Улсын хилийн тухай хуулийн 39.4 дэх хэсэгт заасны дагуу офицер ахлагч нарын 18 гэр бүлийг ажлын байраар хангаж, 1 ахмад хилчинг ажлын байранд зуучилсан. Алба хаагчдад 10 айлын орон сууц барих “Хилчин хотхон”-ны газрын асуудлаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт газар авах хүсэлтээ хүргүүлж, 10 алба хаагчдид өрхийн зориулалттай 0.7 га газрыг өмчлөх эрхийг шийдвэрлэсэн. | 100% |
| 278 | | 4.2.8.3. Хил хамгаалах албыг бэхжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, аян зохион байгуулах | 16 | Хилийн зөрчлийн тоо | | Иргэдийн оролцоо нэмэгдэж, хилийн зөрчил буурсан байна. | “Нэг мянгат малчин-Нэг агт” аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж аяны хүрээнд 2021 онд Мандал сумаас 4, Түшиг сумаас 3, Зүүнбүрэн сумаас 2, 2022 онд Түшиг, Алтанбулаг, Хүдэр сумдын малчдаас 3 агтыг тус тус хүлээн авсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 279 | 4.2.9. Хууль хяналтын байгууллагуудын салбар дундын хамтын ажиллагааг сайжруулна. | 4.2.9.1. Хууль хяналтын байгууллагуудын ажил хэргийн уулзалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах | 90 хувь | Зохион байгуулсан уулзалтын тоо | | Хууль сахиулах байгууллагуудын удирдлагын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжсөн байна. | Шүүх эрх мэдэл болон хууль хяналтын байгууллагуудтай нэгдсэн 5, хэсэгчилсэн 9 удаагийн хамтарсан уулзалтыг хийж, Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Хилийн анги зэрэг байгууллагуудад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс дэмжлэг үзүүлж ажилласан. 2022 онд хууль, хяналтын байгууллагуудын удирдах ажилтны уулзалтыг 2 удаа зохион байгуулж, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар санал солилцож ажилласан. Хууль зүй, дотоод хэргийн яам, Ханнс Зайделийн сангийн ажлын хэсэгтэй хамтран аймгийн Цагдаагийн газрын мэдүүлгийн өрөө, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын уулзалтын өрөөний үйл ажиллагаатай танилцан хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүний эрхийг хэрхэн хангаж байгаад хяналт шалгалтыг хийж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 2023 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр Сүхбаатар суманд зохион байгуулж аймгийн хууль сахиулах байгууллагууд иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөөг өгч ажилласан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 280 | | 4.2.9.2. Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд камер суурилуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх | 80 хувь | Камерын тоо | | 80 хувь | Телекамераар хяналт тавих нь гэмт хэрэг, зөрчлийг богино хугацаанд илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бага хүчээр их талбайд хяналт тавих, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах эрхийг хангах зорилгоор аймгийн төв Сүхбаатар сумand 2021 оны орон нутгийн төсвийн сангийн 47.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар коронавируст халдвар болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх илрүүлж таслан зогсоох зорилгоор замын хяналтын постыг камержуулах ажлыг Сүхбаатар, Шаамар сумын гурвалжингийн пост, 4 зам хяналтын пост зэрэг 4 гол цэгт тус тус байршуулсан. Аймгийн төв болон сумдуудыг теле хяналтын нэгдсэн төвд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж Мандал сумыг теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбох төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 40 цэгт 100 камер байршуулахад 244,0 сая төгрөгийн зардлын төсвийг гаргаж орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Сумдын цагдаагийн хэсгүүдийг теле хяналтын камерийн системд холбох ажлын хүрээнд Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумдын Цагдаагийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэсгийн байруудыг камержуулахад нийт 35,580,000 төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Сүхбаатар, Алтанбулаг сумдын гудамж, зам талбайг камержуулах нийт 833.893.500 сая төгрөгийн төслийг тооцоог гаргаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, аймгийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган баталсан. Сүхбаатар сумын 14 цэгийн 44, Мандал сумын төвийн 6 багийн нутаг дэвсгэрийн 40 цэгийн 145, хяналтын камерыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, хяналтын камерын нэгдсэн төвийг Цагдаагийн газар, хэлтсийн байранд бий болгоод байна. | |
| 281 | | 4.2.9.3. Хууль сахиулах байгууллагуудын орчин нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд жил бүр дэмжлэг үзүүлсэн бөгөөд 2020 онд цар тахлын үед хариуцлагатай эргүүл, постонд үүрэг гүйцэтгэсэн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад аймгийн Засаг | Хэрэгжүүлсэн ажлын тоо | | Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, дэмжлэг үзүүлэн ажиллах ая тухтай нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Шүүхийн шинжилгээний албанд томилогдон ирсэн алба хаагчдыг орон сууцжуулах зорилгоор төвийн дулаан, цэвэр бохирт холбогдсон байгууллагын байранд 11 алба хаагчтай түрээсийн гэрээ байгуулан, тав тухтай амьдрах боломжоор хангасан. Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хамтран хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхээр хамтарсан төлөвлөгөө гарган ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200.0 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дарга, аймгийн Онцгой комиссын даргын шийдвэрээр нийт 39,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | | | | сая төгрөгийн өртөг бүхий Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн 170м2 талбай бүхий 6 ажлын өрөө, автомашины граж бүхий барилгыг “Сэлэнгэ таван хан” ХХК-иар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар барилгын гүйцэтгэл 70 хувьтай байна. Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлсэн “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд “Түр хамгаалах байр”-ны барилгыг 198.409.333 төгрөгөөр үнэлэн үндсэн хөрөнгөнд бүртгэн, үйл ажиллагааг эхлүүлсэн. Түр хамгаалах байрыг орон нутгийн 105.0 сая төгрөгийн төсвөөр дээвэр, сангийн ажлыг засварлан сайжруууллаа. Хилийн ангийн үлээвэр хөгжмийн зэмсэг шинэчлэхэд шаардагдах 59.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж, шинэ техник хэрэгслээр ханган ажиллалаа. | |
| 282 | 4.3.1. Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхолыг нэмэгдүүлэх, | 4.3.1.1. Цэргийн насны залуучуудад цэргийн алба хаах хүсэл сонирхол төрүүлэх комент, | “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, боловсролын түвшинг | Цэргийн жинхэнэ алба хаах залуусын тоо нэмэгдсэн байна | | Хугацаат цэргийн алба хааж буй дайчдыг эргэх, ар гэрийн төлөөллийг оролцуулан | Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачилсан “Бидний бахархал” төслийн арга хэмжээг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1100 орчим сурагчдын дунд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | сурталчилгааны ажил зохион байгуулах | нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг 2017-2020 оны хугацаанд хэрэгжүүлэн дуусч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн VII хуралдаанаар илтгэн хэлэлцүүлж хөтөлбөрийн тайланг “хангалттай” гэж дүгнэсэн. | | | цэргийн өдөр тутмын үйл ажиллагааг харуулсан богино хэмжээний нэвтрүүлэг хийж олон нийтэд хүргэнэ. | “Мөнхөд дурсагдах баатрууд” төрийн бус байгууллагын тэргүүн, доктор, дэд профессор, хурандаа Ж.Өвгөнбүргэд “Монгол Улсын тусгаар тогтнолын үнэ цэнэ” 12 минутын баримтат кино, “Эх оронч үзэл, хүмүүжил” сэдвээр лекц, Монгол Улсын баатрууд, ахмад дайчдын эдэлж хэрэглэж байсан буу, зэвсэг, хөшөө дурсгал бусад 612 ширхэг үзмэрийг дэлгэн байрлуулж, түүхийн мэдлэг олгох зорилгоор тайлбарлаж, харилцан ярилцлагыг зохион байгуулсан. Мөн Хүүхэд, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоороо бахархах, дээдлэн хүндэтгэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, энхийг сахиулагчдын алдар гавьяа, түүхэн замналыг мөнхжүүлэх, сурталчлах зорилгоорУлаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ аймгийн ахлах ангийн 120 гаруй хүүхдүүдэд цэргийн хэргийн анхан шатны мэдлэг, дадлага, хүмүүжил олгох "ЗЭВ" төвийн бүсийн сургалтыг 08 дугаар сарын 16-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай Хилийн цэргийн 0243 дугаар ангитай хамтран зохион байгуулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 283 | | 4.3.1.2. “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх | “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, боловсролын түвшинг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг 2017-2020 оны хугацаанд хэрэгжүүлэн дуусч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн VII хуралдаанаар илтгэн хэлэлцүүлж хөтөлбөрийн тайланг “хангалттай” гэж дүгнэсэн. | “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, хөтөлбөр”-ийн хүрээнд хамрагдах залуучуудын тоог нэмэгдүүлэх | | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн төвшин сайжирч алба хаах залуучуудын тоо нэмэгдэнэ. | Цэрэг татлагын 2022-2023 оны эрүүл мэндийн үзлэгийн судалгааг гаргаж, аймгийн эрүүл мэндийн газартай хамтран Сүхбаатар, Мандал, Сайхан гэсэн 3 бүсэд хуваан сумдын эмнэлгүүдэд хүргүүлэн эрүүлжүүлэх чиглэл өгч тэдгээр идэрчүүдийг ээлжит цэрэг татлагаар тэнцүүлэн 5 хувийг эрүүлжүүлсэн. Засгийн газраас баталсан хяналтын тоог биелүүлсэн. | 100% |
| 284 | 4.3.2. Цэргийн штабын сургалтын төвийн байгуулах. | 4.3.2.1. ЦШ-ын төлөвлөгдсөн сургалт, дадлага хийгдэх, төрийн захиргааны албан хаагчдыг "Цэргийн бэлтгэл" сургалт явуулах орчин бүрдсэн байх | Зүүнбүрэн суманд сургалтын төв байгуулах 5га газрын асуудлыг шийдвэрлэж газрын гэрчилгээ авсан. | Цэргийн бэлтгэл сургалт явуулах орчин, нөхцөл бүрдүүлэх | | Шаардлагатай барилга байгууламжыг барих, тохижилтийн ажлуудыг хийнэ. | Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 82 дугаар тогтоолоор Цэргийн штабын “Дайчилгааны бэлтгэл үүрэгтнүүдийн болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангах зориулалт бүхий сургалтын төв”-ийг байгуулахтай холбогдуулан хашаа, байшин барихад шаардагдах 240.000.000 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба 2023 онд 120.000.000 төгрөгөөр | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хашаажуулах ажлыг хийхээр ажлын зураг төслийг “Орхон Прожект” ХХК боловсруулан, барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтад “И Эс Би Ай” ХХК шалгарч Зүүнбүрэн сумын нутагт байгуулагдах тус сургалтын төвийн 5 га газрыг угсармал “Евро” загварын бетон хийцлэлтэй 4 үе бүхий 2 метр өндөр, 2 метр урт хашааг орох болон гарах чиглэлийн 2 төмөр хаалгатайгаар хийж гүйцэтгэсэн. | |
| 285 | 4.3.3. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, "Дөл" тэмцээнийг зохион байгуулах | 4.3.3.1. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг үе шаттай зохион байгуулах /17 сумын хэмжээнд/ | Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-ийн сурагчидын дунд зохион байгуулсан. | Иргэн-цэргийн харилцаа бэхжихийн зэрэгцээ хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх | | Өсвөр үеийн хүүхдүүд Монгол эх орон, түүх уламжлал, зан заншлаараа бахархах, эх орноо хайрлахын үнэ цэнийг ойлгуулсан байна. | Тус хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын 24 сургуулийн 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд “Монгол Улсын Зэвсэгт хүчин” сэдвийн хүрээнд гар зургийн уралдааныг зохион байгуулсан, Нийт 115 бүтээл ирүүлснээс “Тэргүүн” байрыг Э.Тэргэл, “Дэд” байрыг Д.Энхнаран, “Гутгаар” байрыг Э.Амин-Эрдэнэ нарын бүтээлүүд эхний байруудыг эзэлсэн. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдвийн хүрээнд эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан. “Тэргүүн” байрыг Б.Гансоёмбо, “Дэд” байрыг Энхчимэг, “Гутгаар” байрыг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Г.Оджавхлан нарын эсээ тус тус шалгарсан. | |
| 286 | | 4.3.3.2. Цэрэг спортын "Дөл" тэцээнийг аймгийн хэмжээнд 2 жилд нэг удаа зохион байгуулах | Коронавирустай холбогдуулан тус тэмцээн явагдаагүй болно. /Цэргийн штабын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан. | Өсвөр үеийн хүүхдүүдэд цэрэг эх оронч үндэсний үзэл хүмүүжил төлөвшүүлэх болон бие бялдарын өв тэгш хөгжил олгоход дэмжлэг үзүүлэх | | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлж, бие бялдарын өв тэгш хүмүүжил олгож Иргэн-цэргийн харилцаа бэхжинэ. Тэргүүлсэн баг Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоно. | Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “ДӨЛ-2023” цогцолбор тэмцээнийг сум, бүс, аймаг гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулсан ба ерөнхий боловсролын 34 сургуулийн 1750 гаруй сурагчид, 130 орчим багш нар оролцсон. Тус тэмцээний “Тэргүүн” байрыг Мандал сумын 2 дугаар сургуулийн Б.Тэмүүжин захирагчтай "Сүлд" тасаг, “Дэд” байрыг Мандал 3 дугаар сургуулийн Ж.Энх-Амгалан захирагчтай "Хөх чоно" тасаг, “Гутгаар” байрыг Мандал 5 дугаар сургуулийн Г.Алтан-Эрдэнэ захирагчтай "Билиг" тасаг, “Тусгай” байрыг Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн Б.Сансар захирагчтай “Сүлд” тасаг, “Тусгай” байрыг Сүхбаатар сумын 5 дугаар сургуулийн Н.Даваажаргал захирагчтай “Шонхор” тасаг шалгарсан ба “Тасгийн захирагч”-ийн төрөлд М.Энхбат, “Эсээ бичлэг”-ийн төрөлд Ж.Энх-Амгалан, “Жагсаалын үзүүлэх тоглолт”-ын төрөлд Б.Тэмүүжин захирагчтай "Сүлд" тасаг, “Гардан тулааны үзүүлэх тоглолт”-ын төрөлд Ж.Энх-Амгалан захирагчтай "Хөх чоно" тасаг, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Гэрийн даалгавар”-ын төрөлд Б.Сансар захирагчтай “Сүлд” тасаг, “Гранат шидэлт”-ийн төрөлд Б.Тэмүүжин захирагчтай "Сүлд" тасаг, “Тусгай бэлтгэл /буудлага, хүн эмнэлгийн бэлтгэл, химийн норматив/”-ын төрөлд М.Тэмүүлэл захирагчтай “Тэмүүлэл” тасаг, “Цэргийн байр зүйн” төрөлд Т.Төрболд захирагчтай “Дайчин шонхор” тасаг, “Тактикийн ажиллагаа”-ны төрөлд О.Анар-Эрдэнэ захирагчтай “Элит” тасаг, “Галын бэлтгэл”-ийн төрөлд Д.Нямбаяр захирагчтай “Бүргэдэй” тасаг тус тус шалгарч өргөмжлөл, дурсамж, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Энэхүү арга хэмжээнд хүүхэд, залуучуудад цэрэг эх орон үндэсний үзэл төлөвших, эх орноо хайрлан хамгаалахын ач холбогдлыг ойлгуулсан сургалт болсон. | |
| 287 | 4.3.4. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, бүх нийтийн | 4.3.4.1. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн чиглэлээр төр захиргааны байгууллага, ҮАБХТЧҮББ-ын албан хаагч нартай сургалт зохион байгуулах, аж ахуй нэгж байгууллагуудтай | 17 сумдын “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулсан. | Хуулинд заагдсан арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | | Аймгийн хэмжээнд нэгдсэн дадлага сургуулийг ҮАБХТЧҮББ-тайгаа хамтран хийнэ. | “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу бие бүрэлдэхүүн, техникийг тогтоосон хугацаанд татан нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, холбоо, зарлан мэдээллийн сувгийн бэлэн байдал найдвартай ажиллагааг хангах, тогтмолжуулах, зарлан мэдээлэл хүргэх бүдүүвчийн дагуу цахилгаан холбоо, төрийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх | хамтран орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах | | | | | холбоо, үүрэн холбоо /Мобиком, Скайтел, Юнител, G-mobail/, биет холбоочин зэргийг тодотгон ажилласан. | |
| 288 | | 4.3.4.2. Томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгдсөн сургалт, дадлагыг үе шаттай зохион байгуулах | 17 сумдын "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулсан. | Томилгоот сумангуудын үүрэг гүйцэтгэх ур чадвар нэмэгдэх | | Уламжлалт болон уламжлалт бус аюулаас сэргийлэх, орон нутгийн хамгаалалтын ажилд томилон оролцуулж, дадлага, туршлага суулгасан байна. | Аймгийн Засаг даргын 2023 оны А/03 дугаар захирамжийн дагуу 01 дүгээр сарын 07-21-ний өдрүүдэд 17 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нартай хамтран "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-ний томилгоот нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд гүйцэтгэх үүргийн талаар мэдээ мэдээлэл, онолын сургалтыг зохион байгуулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулсан Стратегийн команд штабын сургуульд 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд бэлтгэл ажлыг хангаж оролцсон. Тус сургуульд Алтанбулаг сумын томилгоот бүрэлдэхүүнийг гарган үүрэг гүйцэтгүүлсэн. Батлан хамгаалах яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 26-наас 27-ны өдрүүдэд "Монгол Улсын аюулгүй байдал ба Батлан хамгаалах нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх бодлогын шинэчлэл" сэдвийн хүрээнд аймаг, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийслэлийн цэргийн штабын дарга нарын сургалтад хамрагдсан. | |
| 5. ТАВ. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | |
| 289 | 5.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих, мэдлэг, олгоно. | 5.1.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих мэдлэг олгох ажил, арга хэмжээ зохион байгуулах | 2020 онд "ногоон төгөл-Ногоон посторт" аяныг зохион байгуулсан. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих мэдлэг олгох ажил, арга хэмжээ зохион байгуулсан эсэх | - | сургууль цэцэрлэгийн барилгыг ус, усны хэмнэлттэй, дулаан алдагдал багатай, сэргээгдэх эрчим хүчээр хангах | Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан, Цагаануур сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 1000 сурагчдад "Ногоон хот, ногоон барилга", "Амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт", "Байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадал" цахим сургалтыг зохион байгуулсан. | 100% |
| 290 | 5.1.2. Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн модлог ургамлыг | 5.1.2.1. Хуш, жодоо, гацуурын үр бэлтгэх, тарих | Ерөө, Мандал, Хүдэр суманд жодооны 5-7 настай суулгацаар 5 га талбайд ойжуулалт хийсэн. | Хуш, жодоо, гацуурын үр бэлтгэх, тарьсан тоо | 60 сая төгрөг | хуш, жодоо, гацуурын үр тарьж ургуулна. | Хүдэр сумын ойн сангийн 81 дүгээр хэсэглэлийн 6.5 дугаар ялгарал буюу Амж, Хонгио толгойд 25 га, Ерөө сумын Банзарын аманд 25 га талбайд сибирь хуш модны 40.0 сая ширхэг тарьцаар ойжуулалтын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тарималжуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | | суманд жодоог мод үржүүлгийн газарт тарьж байна. | | | | ажлыг “Бугант Минж” ХХК хийж гүйцэтгэсэн. | |
| 291 | | 5.1.2.2. Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн үнэт модлог ургамал, байгалийн ховор, ашигт ургамлыг таримaлжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | Мандал суманд жодоог мод үржүүлгийн газарт тарьж байна. | Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн үнэт модлог ургамал, байгалийн ховор, ашигт ургамлыг тарималжуулсан талбайн хэмжээ | 10 сая төгрөг | 5 га талбайд сибирь хуш, жодоо, гацуурын суулгацаар ойжуулалт хийсэн байна. | Ерөө, Хүдэр суманд “Бугант минж” ХХК 50 га талбайд сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн үнэт модлог ургамлаар тарьмалжуулсан. | 100% |
| 292 | 5.1.3. “Ногоон сум” хөдөлгөөнийг өрнүүлнэ. | 5.1.3.1. “Ногоон сум” аяныг өрнүүлэх | 2020 онд "Хоггүй, цэвэрхэн Сэлэнгэ" аяныг зохион байгуулсан. | “Ногоон сум” аяныг өрнүүлсэн эсэх | - | Хүн ам олноор суррьшсан томоохон төв, суурин, сум "Ногоон сум" болсон байна. | “Ногоон сум” аяныг өрнүүлэн аймгийн 17 сум, 6 тосгоны 5219 иргэн, 545 аж ахуйн нэгж, байгууллага мод тарих ажилд оролцож, 7887 м2 цэцгийн мандал, 5976 м2 талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулж, 9,3 сая ширхэг тарьж ургуулж, тохижилт, ногоон байгууламж сайтай сумаар Мандал, Зүүнбүрэн, Баянгол сум шалгарч, аянд 1200 айл өрхийг оролцуулж, иргэдийг ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 293 | | 5.1.3.2. “Ногоон сум” шалгаруулах удирдамжийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулах | 2021 онд "Хоггүй, цэвэрхэн Сэлэнгэ" аяныг зохион байгуулсан. | “Ногоон сум” шалгаруулах удирдамжийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан эсэх | - | - | “Ногоон сум" шалгаруулах удирдамжийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, аймгийн хэмжээнд 7887 м2 цэцгийн мандал, 5976 м2 талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулж, 9,3 сая ширхэг тарьж ургуулан тохижилт, ногоон байгууламж сайтай сумаар Мандал, Зүүнбүрэн, Баянгол сум шалгарсан. | 100% |
| 294 | 5.1.4. Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулна. | 5.1.4.1. "“Био жорлон”-гийн талаарх ойлголтыг иргэдэд олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулна. “Био жорлон” суурилуулах айл өрх, аялал жуулчлалын газруудын судалгааг гаргах. Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах" | 2022 онд "Хоггүй, цэвэрхэн Сэлэнгэ" аяныг зохион байгуулсан. | "“Био жорлон”-гийн талаарх ойлголтыг иргэдэд олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулна. “Био жорлон” суурилуулах айл өрх, аялал жуулчлалын газруудын судалгааг гаргах. Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион | 79,7 | "био-жорлон"-гийн тоо нэмэгдсэн байна. | "“Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх 01 дүгээр албан даалгаврыг гарган ариун цэврийн байгууламжийг сайжруулах чиглэлээр бүлэг заалтыг тусган сумдын гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах, эко жорлонтой болгох үүрэг чиглэл хүргүүлж, 22 нүхэн жорлонг буулгаж, Баруунбүрэн 2, Мандал 4, Алтанбулаг 2 биожорлон, Сүхбаатар сумын “Шунхлай” ШТС 1 боловсон 00-той болж, гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттай бууруулсан. “Жорлон” үндэсний чуулганд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2 мэргэжилтэнг оролцуулж ажилласан. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах" | | | | |
| 295 | | 5.1.5.1. Төв суурин газрын ногоон төгөл, ногоон байгууламжийн судалгаа гаргах, ногоон байгууламж, төгөл байгуулах | Сүхбаатар сумын 5-р багт 3 га талбайд "Ногоон төгөл" байгуулсан. | Төв суурин газрын ногоон төгөл, ногоон байгууламжийн судалгаа гаргах, ногоон байгууламж, төгөл байгуулсан эсэх | 10 сая төгрөг | "нэг хүнд ноогдох ногоон байгуулажийн хэмжээ нэмэгдсэн байна. | 17 сум, 6 тосгоны 527 байршлын 1,438,648 м.кв ногоон байгууламжийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын Урбан цахим системд оруулж, Аймгийн хэмжээнд 7043 м2 цэцгийн мандал, 4012м2 талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулсан. | 100% |
| 296 | 5.1.5. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ. | 5.1.5.2. Гудамж талбайн гэрэлтүүлэг хийх газруудын судалгааг гаргах, суурилуулах | Сумдын гол замуудыг гэрэлүүлсэн. | Гудамж талбайн гэрэлтүүлэг хийх газруудын судалгааг гаргасан эсэх, суурилуулсан эсэх | - | судалгаанд тулгуурлан гэрэлтүүлгийг суурилуулсан байна. | Гудамж талбайн гэрэлтүүлэг хийх газруудын судалгааг гарган Сүхбаатар, Сант, Мандал, Алтанбулаг, Цагааннуур, Зүүнбүрэн, Орхонтуул, Баруунбүрэн, Ерөө сумын Бугант тосгон, Түшиг, Шаамар, Орхон сумдын төв болон гэр хорооллын гудамжны 510 ширхэг гэрэлтүүлгийг суурилуулсан. | 100% |
| 297 | | 5.1.5.3. Камержуулах шаардлагатай газруудын судалгаа, зураглал гаргах | 4 замын хяналтын постыг камержуулсан. | Камержуулах шаардлагатай газруудын судалгаа, зураглал гаргасан эсэх, камержуулалтын тоо | 300 сая төгрөг | хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг ихээр үйлддэг 1 газруудыг камержуулна. | Сүхбаатар сумын 16 цэгийн байршилд 144 ширхэг телекамерыг байршуулж, иргэдийн аюулгүй байдлыг хангаж, өмнөх оныхоос гэмт хэрэг 3,3 хувиар буурсан байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 298 | 5.1.6. Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана. | 5.1.6.2. Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 2021 онд агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийгдсэн. | Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан эсэх | 4 сая | Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаарх сургалт, сурталчилгааны ажлыг 2-оос дээш удаа хийсэн байна. | Аймгийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан "Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөлөл"-ийн талаар олон нийтэд 2 удаагийн мэдээлэл өгч, "Байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт"-ыг аймгийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн 1500 хүүхэд, 17 сум 6 тосгоны 2000 иргэдийг оролцуулан зохион байгуулж, 530 ширхэг сурталчилгааны материалыг тараан зөв дадал хэвшилд сургах ажлыг хийсэн. | 100% |